



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/302

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "б", 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хаваржилт хүндэрсний улмаас зарим сумдын малчдад өвс, тэжээл хүргэхэд зарцуулсан шатах тослох материалын зардалд 4997900 (дөрвөн сая есөн зуун ерэн долоон мянга есөн зуун) төгрөгийг Мал хамгаалах сангаас гаргаж зарцуулахыг Мал хамгаалах сангийн нягтлан бодогч (Я.Баянжаргал)-д зөвшөөрсүгэй.

2 Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Г.Баттулга)-д даалгасугай.

ДАРГА  Л.ГАНБОЛД